

“ДӨРВӨЛЖИН ҮСЭГ - 750”

Олон улсын эрдэм шинжилгээний хурал болов

Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургууль, Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын Хүрээлэн, Монголын Бурханы Шашинтны төв Гандандэгчилэн хийд, Монгол Улсын Их Сургуулийн Номын сан хамтран 2019 оны 5 сарын 30-31-ний өдрүүдэд МУИС-ын Номын сангийн 502 тоот танхимд “ДӨРВӨЛЖИН ҮСЭГ-750” олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулав. Тус хуралд Монгол, БНХАУ, Япон, Австрали улсуудаас 19 судлаач оролцон илтгэл хэлэлцүүлээ.

Үндсэн илтгэлийг судлаач **Р.Отгонбаатар** (Монгол, ШУА, Хэл Зохиолын Хүрээлэн) “Дөрвөлжин үсгийн дурсгалын тойм” сэдвээр хэлэлцүүлсэн бол эрдэм шинжилгээний сарбар хуралдаанд судлаач **Ц.Шагдарсүрэн** (Монгол, Олон улсын Улаанбаатар Их Сургууль) “Монголын дөрвөлжин бичиг хятад хэлний баримт болох нь”, **Гарди** (БНХАУ, Өвөр Монголын Багшийн Их Сургууль) “Пагва ламтан дөрвөлжин үсгийг зохиохдоо уйгуржин үсгийн бүтэц онцлогийг хүлээж лавласан нь”, **Ш.Чоймаа** (Монгол, Монгол Улсын Их Сургууль) “Хос ёсны сургаал хийгээд Сажка бандид Гунгаажалцаны зохиосон Субашид”, **Такаши Мацукава** (Япон, Отани Их Сургууль) “Дөрвөлжин үсгийн хэрэглээний бодит байдлын зарим асуудал”, **Хасбагана** (БНХАУ, Өвөр Монголын Багшийн Их Сургууль) “Төвөдөөс олдсон Луу жилийн хааны зарлигийн бичгийн он жилийг шинжлэх нь”, **С.Янжинсүрэн** (Монгол, МУИС-ШУС) “Цагаан түүх

сурвалж дахь Юань гүрний төрт ёсны үзэл санаа”, **Жамъяан Хайчог** (БНХАУ, Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэн) “Chos rgyal ‘Phags pa and Pivotal Role in the Cultural Enrichment of Qubilai Khan’s Mongol Empire”, **Ц.Батдорж** (Монгол, ШУА, Хэл Зохиолын Хүрээлэн) “Дөрвөлжин бичгийн тогтолцоон дахь эр, эм гийгүүлэгчийн учир”, **Отгон Боржигин** (БНХАУ, Ланжоугийн Их Сургууль) “Some Thoughts on a Counterfeit hP’ags-pa Script Seal Appeared in Lanzhou”, **Саруул** (БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль) “Дөрвөлжин үсгийн сурвалж дахь төгсгөлт үеийн тухай”, **Цагаансар** (БНХАУ, Өвөр Монголын Их Сургууль), “Эрдэмтэн Зууннастын дөрвөлжин үсгийн тухай судалгааг өгүүлэх нь”, **Н.Амгалан** (Монгол, Гандантэгчинлин хийд Эрдэм соёлын хүрээлэн) “Дундговис олдсон дөрвөлжин үсгийн тамга”, **Өлзийбаяр** (БНХАУ, Хөх хотын Ажил мэргэжлийн дээд сургууль) “Бадгар сүмийн дуганы үүдэн дэх дөрвөлжин үсгийн бичээсүүдийг тайлбарлан унших нь”, **Г.Мягмарсүрэн** (Монгол, Дашчойлин хийд Бурханы шашин соёл судлалын хүрээлэн) “Пагва ламаас Их Монголын Юань гүрний хан хөвгүүдэд зориулсан хос ёсны сургаалын тухай”, **Song Hongmin** (БНХАУ, Жинань Их Сургууль) “On the Phenomenon of u ê Being Spelled as ia in hP’ags Script Document of Yuan Dynasty”, **Ц.Мөнх-Эрдэнэ** (Монгол, Дашчойлин хийд Зүүн хүрээ коллеж) “Сажбабын сайн нөмлөл хэмээх шастирын утга агуулга” зэрэг сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн болно.

* * *